

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/40/НА-СТА-ТШЗ

Цахим www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	хуудас:	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn Аудитор: Э.Булганчимэг Утас: 261628 Цахим хаяг: bulganchimege@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал: С.Тунгалаг Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn
---	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл.....	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.1 Завсрын аудитын талаар.....	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Төлбөрийн акт	24
5.2 Албан шаардлага	24
5.3 Зөвлөмж	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	27

Товчилсон үгийн жагсаалт

ДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТҮ	Төрийн үйлчилгээ
ТҮМБ	Төрийн үйлчилгээ мэргэжлийн боловсрол
ТҮШУ	Төрийн үйлчилгээ шинжлэх ухаан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ П.ОЮУНАА ТАНАА

2026.02.25 № 06/420
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсролын сайдын сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай 2025 оны А/404 дүгээр тушаалаар сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийг шинэчлэн баталж, Хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжиж, танин мэдэхүй, нийгэмшлийн суурь болон ерөнхий чадамжийг эзэмшүүлж, сургуульд бэлтгэх зорилгыг дэвшүүлэн 2025-2026 оны хичээлийн жилээс өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгт хэрэгжүүлж эхэлсэн байна.

Боловсролын сайдын 2026 оны А/47 дугаар тушаалаар бага боловсролын сургалтын хөтөлбөрийг 2026-2027 оны хичээлийн жилээс өмчийн бүх хэлбэрийн сургуулиудын I-II ангид, III-V ангид 2027-2028 оны хичээлийн жилээс эхлэхээр тус тус шинэчилж, баталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сургуулийн өмнөх болон бага боловсролын I-V ангийн багшийн ном, сурах бичиг (сурагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтэр)-ийн дизайны концепц боловсруулах, зураг, хэвлэлийн эх бэлтгэх байгууллагыг сонгон шалгаруулах зарлалыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан ч худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Боловсролын ерөнхий газарт шилжүүлснээс шалтгаалан үр дүн гараагүй, хүчингүй болсон байна.

Бусад асуудал

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь тайлант хугацаанд 3 зорилтын 63 арга хэмжээг төлөвлөснөөс гүйцэтгэл 92.7 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ЦНАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	101,447,207.10	144,768,289.00
33	АВЛАГА	99,231,207.10	143,052,289.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	933,918.10	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	98,297,289.00	143,052,289.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,216,000.00	1,716,000.00
35400	Хангамжийн материал	2,216,000.00	1,716,000.00
35440	Түлш, шатах тослох материал	500,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	1,716,000.00	1,716,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	121,847,706.39	157,187,590.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	121,847,706.39	157,187,590.41
39200	Биет хөрөнгө	121,847,706.39	157,187,590.41
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,500,000.00	69,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(57,916,666.80)	(69,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	317,953,474.40	434,437,474.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(224,942,809.10)	(287,555,113.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,683,962.00	115,683,962.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(98,430,254.11)	(105,378,732.43)
39301	Программ хангамж	1,470,000.00	1,470,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,470,000.00)	(1,470,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	223,294,913.49	301,955,879.41
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,514,951.23	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,514,951.23	-
41300	Өглөг	1,514,951.23	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,514,951.23	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	221,779,962.26	301,955,879.41
51	Засгийн газрын хувь оролцоо	221,779,962.26	301,955,879.41
51100	Засгийн газрын оруулсан капитал	96,015,446.35	96,015,446.35
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	96,015,446.35	96,015,446.35
51200	Хуримтлагдсан үр дүн	125,764,515.91	205,940,433.06
51210	Өмнөх үеийн үр дүн	81,826,724.01	125,764,515.91
51220	Тайлант үеийн үр дүн	43,937,791.90	80,175,917.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	223,294,913.49	301,955,879.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,612,925,394.40	5,045,720,998.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,260,552.40	5,045,720,998.69
120	Нийтлэг татварын бус орлого	27,260,552.40	112,180,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	27,260,552.40	112,180,000.00
122	Тусламжийн орлого	-	4,933,540,998.69
1221	Хандив тусламж /дотоод/	-	4,933,540,998.69
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,431,128,640.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	4,431,128,640.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	502,412,358.69
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	132,697,325.69
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	70,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	299,715,033.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,585,664,842.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,746,797,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,746,797,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	838,867,542.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	133,588,950.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,950,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	530,328,592.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,568,987,602.50	4,965,545,081.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,568,987,602.50	4,965,545,081.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,545,382,025.56	4,883,130,047.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,134,661,498.21	2,222,290,530.13
210101	Үндсэн цалин	1,069,216,737.27	1,278,030,818.05
210102	Нэмэгдэл	685,901,287.60	550,083,518.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	183,428,832.88	244,124,890.70
210104	Урамшуулал	101,482,246.00	150,051,302.77
210105	Гэрээт ажлын хөлс	94,632,394.46	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	274,393,742.93	274,858,096.38
210201	Тэтгэврийн даатгалын зардал	189,844,047.31	195,697,030.29
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	21,337,500.00	19,560,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	10,668,800.00	9,880,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	10,053,361.27	9,880,300.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	42,490,034.35	39,839,866.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,307,544.35	1,190,448.00
210301	Гэрэл, цахилгаан	320,163.00	83,689.00
210302	Түлш, халаалт	1,106,754.35	1,106,759.00
210304	Байрны түрээс	1,880,627.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	24,465,798.80	17,024,917.11

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	13,091,600.00	5,839,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,580,000.00	2,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,181,598.80	1,529,227.11
210404	Ном, хэвлэл	1,710,000.00	1,699,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,902,600.00	5,856,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,780,088,787.00	1,968,405,790.45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,779,855,287.00	1,960,460,392.45
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	6,180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	117,100.00	171,720.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	83,400.00	250,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	53,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,290,678.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,328,464,654.27	399,360,265.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00	6,372,418.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,228,953,603.00	311,843,731.70
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	87,511,051.27	81,144,115.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,605,576.94	82,415,033.79
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	15,061,089.79
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	15,061,089.79
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	15,061,089.79
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	14,894,832.79
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	166,257.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,678,000.00	67,353,944.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	67,353,944.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,678,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,927,576.94	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,644,476.94	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,283,100.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	43,937,791.90	80,175,917.15
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	43,937,791.90	80,175,917.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,585,664,842.00	5,031,838,287.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,031,838,287.69
122	Тусламжийн орлого	-	5,031,838,287.69
1221	Хандив тусламж /дотоод/	-	5,031,838,287.69
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,431,128,640.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	4,431,128,640.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	600,709,647.69
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	132,697,325.69
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	70,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	398,012,322.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,585,664,842.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,746,797,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,746,797,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	838,867,542.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	133,588,950.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,950,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	530,328,592.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,568,474,942.00	5,027,534,287.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,568,474,942.00	5,027,534,287.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,446,572,076.06	4,802,066,964.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,133,146,546.98	2,222,290,530.13
210101	Үндсэн цалин	1,067,701,786.04	1,278,030,818.05
210102	Нэмэгдэл	685,901,287.60	550,083,518.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	183,428,832.88	244,124,890.70
210104	Урамшуулал	101,482,246.00	150,051,302.77
210105	Гэрээт ажлын хөлс	94,632,394.46	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	265,855,895.93	273,924,178.28
210201	Тэтгэврийн даатгалын зардал	181,306,200.31	194,763,112.19
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	21,337,500.00	19,560,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	10,668,800.00	9,880,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	10,053,361.27	9,880,300.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	42,490,034.35	39,839,866.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,307,544.35	1,190,448.00
210301	Гэрэл, цахилгаан	320,163.00	83,689.00
210302	Түлш, халаалт	1,106,754.35	1,106,759.00
210304	Байрны түрээс	1,880,627.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	23,883,398.80	16,524,917.11
210401	Бичиг хэрэг	13,091,600.00	5,839,700.00

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	1,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,181,598.80	1,529,227.11
210404	Ном, хэвлэл	1,710,000.00	1,699,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,900,200.00	5,856,990.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,781,613,787.00	1,969,920,741.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,781,380,287.00	1,961,975,343.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	6,180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	117,100.00	171,720.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	83,400.00	250,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	53,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,290,678.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,238,764,903.00	318,216,149.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00	6,372,418.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,226,764,903.00	311,843,731.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,902,865.94	225,467,322.79
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	158,113,378.79
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	158,113,378.79
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	158,113,378.79
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	14,894,832.79
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	166,257.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	143,052,289.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,678,000.00	67,353,944.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	67,353,944.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,678,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	110,224,865.94	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,644,476.94	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	101,580,389.00	-
III	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	17,189,900.00	4,304,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	17,189,900.00	4,304,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,189,900.00	4,304,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,189,900.00	4,304,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,189,900.00	4,304,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(17,189,900.00)	(4,304,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,015,446.35	81,826,724.01	177,842,170.36
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,015,446.35	81,826,724.01	177,842,170.36
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ноогдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	43,937,791.90	43,937,791.90
11	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,015,446.35	125,764,515.91	221,779,962.26
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,015,446.35	125,764,515.91	221,779,962.26
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ноогдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	80,175,917.15	80,175,917.15
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,015,446.35	205,940,433.06	301,955,879.41

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	6,217,756,100.00	4,416,233,807.21	1,801,522,292.79	71.0
12	Татварын бус орлого	6,217,756,100.00	4,416,233,807.21	1,801,522,292.79	71.0
122	Тусламжийн орлого	6,217,756,100.00	4,416,233,807.21	1,801,522,292.79	71.0
122005	Төсвөөс санхүүжих	6,217,756,100.00	4,416,233,807.21	1,801,522,292.79	71.0
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	6,217,756,100.00	4,416,233,807.21	1,801,522,292.79	71.0
21	Урсгал зардал	6,217,756,100.00	4,416,233,807.21	1,801,522,292.79	71.0
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	6,150,221,500.00	4,348,879,863.21	1,801,341,636.79	70.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,123,116,700.00	2,120,100,031.13	3,016,668.87	99.9
210101	Үндсэн цалин	1,210,545,700.00	1,175,840,319.05	34,705,380.95	97.1
210102	Нэмэгдэл	541,680,700.00	550,083,518.61	(8,402,818.61)	101.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	243,300,200.00	244,124,890.70	(824,690.70)	100.3
210104	Урамшуулал	127,590,100.00	150,051,302.77	(22,461,202.77)	117.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	267,512,200.00	263,096,933.28	4,415,266.72	98.3
210201	Тэтгэврийн даатгал	182,036,900.00	183,935,867.19	(1,898,967.19)	101.0
210202	Тэтгэмжийн даатгал	21,416,100.00	19,560,600.00	1,855,500.00	91.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,618,400.00	9,880,300.00	738,100.00	93.0
210204	Ажилгүйдлийн даатгал	10,608,700.00	9,880,300.00	728,400.00	93.1
210205	Эрүүл мэндийн даатгал	42,832,100.00	39,839,866.09	2,992,233.91	93.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,235,900.00	1,190,448.00	3,045,452.00	28.1
210301	Гэрэл, цахилгаан	1,570,600.00	83,689.00	1,486,911.00	5.3
210302	Түлш, халаалт	1,107,600.00	1,106,759.00	841.00	99.9
210303	Цэвэр, бохир ус	298,600.00	-	298,600.00	-
210304	Байрны түрээс	1,259,100.00	-	1,259,100.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	21,476,500.00	15,379,917.11	6,096,582.89	71.6
210401	Бичиг хэрэг	7,908,700.00	4,694,700.00	3,214,000.00	59.4
210402	Тээвэр, шатахуун	700,000.00	1,600,000.00	(900,000.00)	228.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,518,300.00	1,529,227.11	4,989,072.89	23.5
210404	Ном, хэвлэл	1,499,000.00	1,699,000.00	(200,000.00)	113.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,850,500.00	5,856,990.00	(1,006,490.00)	120.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,390,000.00	1,390,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,390,000.00	1,390,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,431,832,400.00	1,797,082,399.99	1,634,750,000.01	52.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,416,635,700.00	1,789,137,001.99	1,627,498,698.01	52.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	6,180,000.00	3,820,000.00	61.8
210803	Даатгалын үйлчилгээ	173,000.00	171,720.00	1,280.00	99.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	250,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	72,200.00	53,000.00	19,200.00	73.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,984,800.00	1,290,678.00	2,694,122.00	32.4

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	716,700.00	-	716,700.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,657,800.00	150,640,133.70	150,017,666.30	50.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,390,400.00	6,372,418.00	17,982.00	99.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	294,267,400.00	144,267,715.70	149,999,684.30	49.0
213	Урсгал шилжүүлэг	67,534,600.00	67,353,944.00	180,656.00	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,534,600.00	67,353,944.00	180,656.00	99.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,533,600.00	67,353,944.00	179,656.00	99.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.00	-	1,000.00	-
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал	118	-	118	-
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100
62	Ажиллагсдын тоо	65	59	(6)	90.8
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	56	52	(4)	92.9
620003	Үйлчлэх ажилтан	3	1	(2)	33.3
620004	Гэрээт ажилтан	5	5	-	100.0
65	Орон тооны мэдээлэл	65	59	(6)	90.8
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	54	48	(6)	88.9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	-	100.0
650010	Гэрээт ажилтан	5	5	-	100.0
66	Нийт тэтгэвэрт гарагч	1	2	1	200.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	1	2	1	200.0

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

				/төгрөгөөр/
Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	-	600,709,647.69	
12	Татварын бус орлого	-	600,709,647.69	
122	Тусламжийн орлого	-	600,709,647.69	
1221	Хандив тусламж /дотоод/	-	600,709,647.69	
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	600,709,647.69	
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	132,697,325.69	
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	70,000,000.00	
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	398,012,322.00	
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	457,491,101.69	
21	Урсгал зардал	-	457,491,101.69	
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	-	457,491,101.69	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	102,190,499.00	
210101	Үндсэн цалин	-	102,190,499.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	10,827,245.00	
210201	Тэтгэврийн даатгал	-	10,827,245.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,145,000.00	
210401	Бичиг хэрэг	-	1,145,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	175,752,341.69	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	175,752,341.69	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	167,576,016.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	167,576,016.00	
4	Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-	143,218,546.00	
5	Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	(143,218,546.00)	
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(143,218,546.00)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь Монгол Улсад боловсролын хөгжлийн асуудлаар суурь болон хавсарга судалгаа хийх, боловсролын бодлого, төлөвлөлт, шийдвэр, боловсруулахад судалгааны мэдээллээр хангах, боловсролын бодлого төлөвлөлт, боловсролын эдийн засаг, менежмент, хүний хөгжил болон сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүн, боловсролын хөгжлийн ирээдүйн чиг хандлагын чиглэлээр, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг эрхлэх, байгууллага, иргэд, олон нийтэд судалгаа, шинжилгээний үр дүнгийн мэдээллээр үйлчлэх чиг үүрэгтэй, Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Эрхэм зорилгоо “Боловсролын судалгаагаар олон улсын түвшинд хүрсэн эрдэм, шинжилгээ, арга зүйн тэргүүлэгч байгууллага байна” гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус хүрээлэн нь Боловсролын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 5 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн батлагдсан;
- Сангийн сайдын 2025 оны “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;
- Боловсролын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай журам шинэчлэн батлагдсан;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/10 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн бүтэц орон тооны дээд хязгаарт дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтны орон тоог батлаагүй, дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтангүй байна.

Тайлант онд Боловсролын яамны салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Сангийн сайдын шинэчлэн батлагдсан заавар журмын дагуу нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад тохироогүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 78,661.0 мянган төгрөгөөр буюу 35.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Авлага	99,231.2	143,052.3	43,821.1
Бараа материал	2,216.0	1,716.0	(500.0)
Үндсэн хөрөнгө	121,847.7	157,187.6	35,339.9
Нийт хөрөнгө	223,294.9	301,955.9	78,661.0
Богино хугацаат өр төлбөр	1,515.0	-	(1,515.0)
Засгийн газрын хувь оролцоо	221,780.0	301,955.9	80,175.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	223,294.9	301,955.9	78,661.0

Дээрх хүснэгтээс харахад авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Авлагын дансны үлдэгдэл 43,821.1 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны 143,218.6 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлснээс шалтгаалсан.
- Бараа материалын дансны үлдэгдэл 500.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 378,814.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 379,314.1 мянган төгрөгийн бараа материалыг албан хэрэгцээнд зарцуулснаас шалтгаалсан.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 35,339.9 мянган төгрөгөөр өссөн нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 107,030.0 мянган төгрөгийн, Тэгш боломжийг бүрдүүлэх заавал суралцахуйг дэмжих төслөөс 5,150.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 4,304.0 мянган

төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч, 81,144.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулснаас шалтгаалсан.

- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 1,515.0 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүний орлогын албан татварын оны эхний үлдэгдлийг барагдуулснаас шалтгаалсан.
- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 80,175.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалсан.

Судалгааны үр дүн:

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс Хас эрин орчил ХХК-ийн Динамик 1.0 санхүүгийн программыг ашиглаж байгаа ба дэлгэрэнгүй судалгааг Д301/04 дүгээр маягтаар баталгаажуулж, баримтжуулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 17,175,959.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 4,996,462.9 мянган төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 920,198.5 мянган , бараа үйлчилгээний бусад зардлыг 732,900.0 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 209,894.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 186,329.5 мянган төгрөг, ажил олгогчоос олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 110,286.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 21,977.4 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 16,300.0 мянган төгрөг мянган, нормативт зардлыг 1,100.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 418.3 мянган төгрөгөөр тус тус бууруулж 9,980,092.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь 2025 төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 2025 оны 7 дугаар сард 3,638,638.5 мянган төгрөгөөр 12 дугаар сард 53,815.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,287,639.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,431,128.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 4,416,233.8 мянган төгрөгийг зарцуулж, 14,894.8 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,416,233.8 мянган төгрөг буюу 70.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 173,379.5 мянган төгрөг, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлын төсвийг 1,697,845.1 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын төсвийг 180.7 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт (хувь)
1	Үндсэн үйл ажиллагааны зардал 71809-80101	3,486,982.1	1,789,137.0	(1,697,845.1)	51.3
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 71809-81834	2,733,122.4	2,559,742.9	(173,379.5)	93.7
3	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 71809-80802	67,534.6	67,353.9	(180.7)	99.7

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Боловсролын сайдын 2022 оны А/10 дугаар тушаалаар орон тооны дээд хязгаарыг удирдах 1, гүйцэтгэх 56, үйлчлэх 3, гэрээт 5 нийт 65 орон тоо баталж, гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 52, үйлчлэх 1 нийт 54 орон тоотой ажилласан байна. 2026 оны төсвийн төсөлд удирдах 1, гүйцэтгэх 57, үйлчлэх 1 нийт 59 орон тоотой ажиллахаар төлөвлөж, дээд шатны захирагчид хүргүүлсэн байна.
- Шалгагдагч байгууллагын 2025 оны Б/01 дүгээр тушаалаар албан хаагчдын хоол унааны нэмэгдлийг ажлын нэг өдөрт 20.0 мянган төгрөгөөр тооцож баталсан байна. Үүнд: албан хаагчид ногдох 1 өдрийн хоолны хөнгөлөлтийг 18.0 мянган, унааны зардлыг 2.0 мянган төгрөгөөр тогтоож, тайлант хугацаанд хоол унааны хөнгөлөлтөд нийт 243,300.0 мянган төгрөгийг олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 244,124.9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Тайланд хугацаанд гадаад томилолт, гадаад зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг төлөвлөөгүй, гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй байна.
- Сургалт судалгааны зардалд 330,295.4 мянган төгрөг төсөвлөж, зарцуулсан нь сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах багийг зайлшгүй шаардлагаар тусгаарлаж ажиллуулах, сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийг орон нутаг, нийслэлийн багш нарт таниулах, багш нарыг чадавхжуулах сургалтыг бүсчлэн, үе шаттайгаар зохион байгуулсантай холбоотой байна.
- Сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын сургалтын хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд таниулахаар “Амгалан дэлхий” ТББ-тай 16,700.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд Сангийн яамнаас 2024 оны үлдэгдлээс татан төвлөрүүлсэн 98,297.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан, Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төслийн 237,317.3 мянган төгрөг, Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслөөс 2,397.7 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого, Хөвсгөл аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас хүүхдийн цогц оношилгооны 60,000.0 мянган төгрөгийн орлого, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2025 оны А/67 дугаар тушаалаар хөтөлбөр арга хэмжээний зардлын санхүүжилтэд олгосон 70,000.0 мянган төгрөг, хэрэгслийг сургалтад ашиглах судалгааны зардалд 24,497.3 мянган төгрөг, НҮБ-ийн хүүхдийн сангийн санхүүжилт 70,700.0 мянган төгрөг, Япон улсад төвтэй хүүхдийг ивээх сангаас олгосон 37,500.0 мянган төгрөг, нийт 600,709.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 102,190.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 10,827.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 1,145.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 175,752.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 167,576.0 мянган төгрөгийг зарцуулж, 143,218.6 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/							
№	Хөтөлбөр	Батлагдсан ажлууд	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71809/81834 /210801/	Боловсролын багц хуулийн хүрээнд боловсролын үзэл баримтлал батлуулж, хөтөлбөрийн шинэчлэл сурах бичиг хэрэглэгдэхүүн боловсруулах, турших үйл ажиллагаа	2025-2027	Сургуулийн өмнөх боловсрол, Бага боловсрол, Суурь боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулах	85%	3,036,942.6	1,427,080.4
2	71809/81834 /210801/	Хүүхдийн академик үгийн нөөцийг тогтоож түвшинд оноох судалгааны баталгаажилтын ажил	2025-2026	Тайлбар толь бичгийн үгийн тайлбарт хяналт хийх, хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гарсны дагуу тайлбарыг сайжруулсан. I үе шатны баталгаажилтын ажлын хүрээнд сорил боловсруулсан. I үе шатны баталгаажилтын ажлын хүрээнд мэдээлэл цуглуулж, шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан. II үе шатны ҮОҮ, академик ба В1, В2 түвшний үгийн орчуулга, корпусын шинжилгээ хийж, тайлан гарсан. Нөхцөл байдлын судалгаа хийж, тайлан гарсан. Баримт бичгийн харьцуулсан судалгааг хийж, тайлаг гарсан. Зургийн сан бүрдүүлсэн. 800 зураг бэлэн болж, тайлан гарсан. II үе шатны академик үгийн жагсаалт боловсруулж, тайлан гарсан. II үе шатны В1, В2 түвшний үгийн жагсаалт боловсруулж, тайлан гарсан. I үе шатны үгийн жагсаалтад хяналт хийж, хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргасан тайлан гарсан.	80%	400,000.0	282,056.6
3	71809/81834 /210801/	Эксел хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны зардал	2025	Хөдөө орон нутгийн багш сурагчдын англи хэлний түвшнийг сайжруулах	100%	80,000.0	80,000.0

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь тайлант онд 950,000.0 мянган төгрөгийн 1 ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авахаар төлөвлөсөн боловч хэрэгжүүлэх хөтөлбөрийн хугацаа хойшлогдсоноос шалтгаалан тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь тайлант хугацаанд шууд худалдан авалтаар албан хэрэгцээнд бэлэн бүтээгдэхүүн 38,431.8 мянган төгрөг, бичиг хэргийн материал 23,229.1 мянган төгрөг, аж ахуйн материал 307,297.2 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 3,106.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 6,750.0 мянган төгрөг, нийт 378,814.1 мянган төгрөгийн бараа материал, 4,304.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах үндсэн хөрөнгийн үнэ цэн, цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг, Ш.Солонго нар гүйцэтгэж, чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Булганчимэг, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардал 6,812,726.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 68,127.3 мянган төгрөгөөр тогтоож санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөгөө хөтөлбөрийг батлуулсан.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон хязгаарласан арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн шилэн данстай холбоотой 1 зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 171 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.8 "Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол мэдээлэх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин, шилэн дансны хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар нийт 965,086.2 мянган төгрөгийн 6 алдааг залруулсан. Үүнд:

- 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 16 нэр төрлийн нийт 184,598.0 мянган төгрөгийн хөрөнгөд хяналтын, түүвэрчилсэн тооллого хийж гүйцэтгэхэд эд хариуцагч нарт картын хувийг олгоогүй, хөрөнгө тус бүрийг кодолж бүртгээгүй;
- Бараа материалын ажил гүйлгээг Агуулахын бүртгэл НХМаягт БМ-5 -д бүртгээгүй;
- Ажиллагсдад олгосон цалингийн урьдчилгаа 90,650.0 мянган төгрөгийг өглөгийн дансанд бүртгэж тайлагнасан;
- 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан заавар аргачлалын дагуу тайлагнаагүй;
- Ашиглалтад байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 141,065.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй;
- Шилэн дансны 5 сая төгрөгөөс дээш дүнтэй 257,286.6 мянган төгрөгийн 18 удаагийн зарлагын гүйлгээ, 291,486.0 мянган төгрөгийн 2 удаагийн орлогын гүйлгээг мэдээлээгүй, 1 удаагийн орлогын гүйлгээг зөрүүтэй мэдээлсэн;

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 284.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 450.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 албан шаардлагын хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	450.0	1	450.0	100.0
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Зөвлөмж	3	284.0	3	284.0	100.0
Нийт дүн	5	734.0	5	734.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн стандарт, Сангийн сайдын шинэчлэн баталсан заавар журмуудад нийцүүлэн шинэчлэн баталсан эсэхийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 58,981.7 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 58,981.7 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 14,894.8 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулаагүй;
- Авлагын дэлгэрэнгүй бүртгэлд цалингийн 34,615.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 9,471.8 мянган төгрөгийг тус тус сөрөг утгатай бүртгэсэн;
- Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын А/3 дугаар тушаалын дагуу иж бүрэн тайлагнаагүй зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 22,040.0 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрсэнд, 170.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3,360.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 18,510.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 22,040.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 68,127.3 мянган төгрөгөөс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Сэлэнгэ аймагт ажилласан албан томилолтын тооцоог бодохдоо ирсэн явсан хоногийг 1 хоногоор тооцоогүйгээс 1 ажилтанд 170.0 мянган төгрөгийн томилолтыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4 “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон албан томилолтын зардлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Албан томилолтын хуудсанд томилолтоор ажилласан хоног тэмдэглээгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 4 ажилтанд 3,360.0 мянган төгрөгийн зардал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4 "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтын хуудсыг бүрэн хөтөлдөггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цахим баримттай холбоотой асуудал

Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнгээс 18,510.0 мянган төгрөгөөр дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" 20 дугаар зүйлийн 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөрийн баримтын цахим системийн гүйлгээнд хяналт хэрэгжүүлж, тооцоог тухай бүр тулгаж ажиллах.

2. Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнтэй холбоотой асуудал

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 141,065.6 мянган төгрөгийн хөрөнгө байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, бодит үнэ цэнээр үнэлээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1 "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоох саналыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн гүйцэтгэлийн тайланд 14,894.8 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулаагүй.	1	14,894.8	-	-	1	14,894.8	1	14,894.8	-	-	-	-
2	Авлагын дэлгэрэнгүй бүртгэлд цалингийн 34,615.1 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 9,471.8 мянган төгрөгийг тус тус сөрөг утгатай бүртгэснийг	1	44,086.9	-	-	1	44,086.9	1	44,086.9	-	-	-	-
3	Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын А/З дугаар тушаалын дагуу иж бүрэн тайлагнаагүйг	1	-	-	-	1	-	1	-	-	-	-	-
	Дүн	3	58,981.7	-	-	3	58,981.7	3	58,981.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Албан томилолтын тооцоог бодохдоо ирсэн явсан хоногийг 1 өдрөөр тооцоогүйгээс 1 ажилтанд нийт 170.0 мянган төгрөгийн томилолтыг илүү олгосон	1	170.0	1	170.0	-	-	-	-	-	-	-	-
2	Ажилласан хоногийг тэмдэглээгүй албан томилолтын хуудсаар 4 ажилтанд 3,360.0 мянган төгрөгийн албан томилолтын олговрыг олгосон	1	3,360.0	-	-	1	3,360.0	-	-	-	-	-	-
3	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнгээс 18,510.0 мянган төгрөгөөр дутуу байна.	1	18,510.0	-	-	-	-	1	18,510.0	-	-	-	-
4	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 141,065.6 мянган төгрөгийн хөрөнгө байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, бодит үнэ цэнээр үнэлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	Дүн	4	22,040.0	1	170.0	1	3,360.0	2	18,510.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
				Үүнээс		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны цахим хуудсанд 171 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 104/A0150458

Улаанбаатар хот

САГ - 2026/40/НА - СТА - ПШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сэлэнгэ аймагт ажилласан албан томилолтын тооцоог бодохдоо ирсэн явсан хоногийг 1 хоногоор тооцоогүйгээс 1 ажилтанд 170,000.00 /Нэг зуун далан мянган/ төгрөгийн томилолтыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4 "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6 "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон 170,000.00 /Нэг зуун далан мянган/ төгрөгийн албан томилолтын зардлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч /П.Оюунаа/, ахлах нягтлан бодогч /Б.Цэрэнханд/ нарт хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
С.ТУНГАЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 502/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/40/КА -СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтын хуудсанд томилолтоор ажилласан хоног тэмдэглээгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 4 ажилтанд 3,360,000.00 /Гурван сая гурван зуун жаран мянган/ төгрөгийн зардал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4 "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан томилолтын хуудсыг бүрэн хөтөлдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч /П.Оюунаа/, ахлах нягтлан бодогч /Б.Цэрэнханд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
С.ТУНГАЛАГ